

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Баасанжав	Дугаар	L287
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Рашаант сум
Төрсөн газар	Рашаант сум	Төрсөн он	1933
Ажил мэргэжил	Хийдийн лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Рашаантын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨРА 065
Одоогийн сүм хийд	Дашдаржаалийн	Сүм хийдийн дугаар	ХӨРА 018
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Рашаантын хүрээ

Мөнхбат: Тэгэхээр Баасанжав гуай таниас энэ асуултыг асууя. Эхлээд энэ газарзүйн байрлалаасаа болохоор энэ Сэлэнгэ мөрнийхөө урд биед тийм ээ, одоогийн Булган аймгийнхаа Рашаант сум, тухайн үеийн нэр томъёогоор бол Сайн ноёын хан аймгийн Мэргэн гүний хошуу гэж байгаа тийм ээ. Тэгэхээр Архангай аймаг энд бас их оролцож байгаа.Энийг та тодруулж хэл дээ?

Баасанжав: Архангай аймгийн Мэргэн гүний хошууны Даравбандидын хийд гэж анх байгуулагдсан юм гэнэ лээ.

Мөнхбат : Нэлээн дээр үеийнх юм гэсэн, таны сонссоноор одоо хичнээн жилийн өмнө баригдсан хийд юм бол?

Баасанжав: За ингэхлээр зэрэг бол Даравбандидын хийд чинь бол анхан чухам сайн оныг нь хэлж мэдэхгүй байна, би...

Мөнхбат: Зургаан жаран өнгөрсөн гэж түрүүн?

Баасанжав: Зургаан жаран өнгөрсөн гэж би дуулсан. Тэрнээс өмнө анхан бүр байгуулагдахдаа болвол Дулаан хан гэдэг, Дайшын суга гэдэг газар анхан бий болсон юм гэнэ лээ.За тэрнээсээ шинжилгээ хийлгээд болохгүй болохлээр зэрэг энэ Цагаан-Уул гэдгийн энгэрт хүрч ирсэн юм гэнэ лээ.Тэгээд цаашаа болохгүй , тогтнож сайн чадахгүй байна гэж ингэж үзээд энд шинжилгээ хийсэн.Аа энд чинь хүрч ирээд шинжилгээ хийгээд, тусгай юу болвол юу яасан, тэр аянчингууд болвол зурхайч хүн явсан байгаа юм. Шинжилгээний зурхайч хүн.За энэ Рашаант сумын Даравбандидын хийд чинь яг энд тогтвол, энэ нутаг тогтож болохоор газар юм аа гээд, ингээд нүүхдээ нэг бамбайгаа орхиод явсан байдаг юм байна лээ гэж нэг ийм түүх байдаг юм байна лээ.Тэгэхлээр зэрэг бол энийг юу яахлээр бол хойд дэнж гэдэг бол одоо идэж үүх юмаар элбэг ийм юм байна. Энэ урд голдоо хийдээ байгуулах юм бол эрдэм номоор цацарсан ийм газар байна аа. Энх тал гэдэг газар байгуулах юм бол эд баялгаар элбэг ийм газар байх юм аа. Энэ хийдийг хаанаа тогтохыг тэр Даравбандид мэднэ ээ гэж ингэж хэлээд явсан юм гэнэ лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат :Тэгэхээр одоо анх байгуулагдсан цагаасаа хоёр ч одоо бууриа солиод гурав дахь буурь нь одоо өнөөдрийн энэ туурь болж байна, тийм ээ?

Баасанжав: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр тэр одоо Дулаан хан, Цагаан-Уул гэдэг газрууд өнөөдрийн энэ Рашаант сумын нутагт байна уу?

Баасанжав: Дулаан хан бол манай Рашаантын гол шүтээн уул байгаа юм.

Цагаан-Уул бас шүтээн уул байгаа юм. Тэгээд Булганыхаа өвөрт хүрч ирсэн юм аа.

Мөнхбат: Энэ хийдийн туурийн яг ард байгаа уул бол Булган уул гэж байгаа, тийм ээ?

Баасанжав: Тийм.

Мөнхбат :Тэгэхээр одоо Булган уулынхаа өвөрт?

Баасанжав: Булган уулынхаа өвөрт, одоо энэ чинь Гурван Булган гэж манай багшууд тэгж хэлж байсан.Гурван булган байгаа юм аа, дацан болгоны хийдийн шавь нар очиж тахидаг юм шүү гэж ингэж ярьсан юм аа.Өшөө юм бол мэдэхгүй юм аа.

Мөнхбат. За тэгэхээр эндээс бид нар одоо нэгэнт энэ сүм хийдийн түүхийг судалж яваа улс учраас бас нэг асуулт асуумаар санагдаж байна аа, таниас.Тэгэхээр монголын буддын шашны түүхэнд одоо олон олон хутагт хувилгаадүүд төрж гарсан байдаг аа. Тэгэхээр одоо ер нь энэ хүрээг үндэслэсэн тэр Даравбандид гэдэг хүн одоо ямар хүн байв аа, энэ хүний одоо талаар, тэр бурхан номын ид шидийн талаар одоо танд мэдсэн дуулсан юмнаасаа хуваалцахгүй юу, та?

Баасанжав: За тэгэхлээр зэрэг би бол одоо нэг их мэдээ дуулаад байсан юм байхгүй. Энд бол одоо Архагай аймаг гэсэн гурван түшмэд лам явсан байгаа юм. За тэгэхлээр зэрэг тус тусынхаа дэрэн дээр мөнгөн аяган дотор үс хийгээд за цэцэг дэлгэрсэн газар яг нэг нь хоцорно. За бусад нь бол хэн түрүүлж цэцэг дэлгэрнэ тэр лам эндээ хоцорно гээд гурвуулаа унтсан юм гэнэ лээ.Тэгэхлээр манай Мэргэн гүний хошууны лам, нэг сэрээд наадуулаасаа түрүүлж нэг сэрээд харсан чинь аяган дотор нь цэцэг дэлгэрчихсэн байсан юм гэнэ лээ. За энэ чинь болж байна гээд тэгээд тэр зуур унтчихсан чинь өнөөдхийг нь солиод анги хүн өөрийнхөө толгойн дээр тавьсан байсан юм гэнэ лээ.Тэгээд манай Даравбандид бол энэ их хошуу нутгийг амлаж авч суусан юм гэнэ лээ л гэж дуулсан. Тэрнээс бусдыг бол сайн тодруулж мэдэхгүй юм аа.

Мөнхбат: Энэ бол домог тийм ээ?

Баасанжав: Тийм, домог.

Мөнхбат: Би бас нэг сонсож байсан домог байна. Та түрүүн энэ ярилцлагын эхэнд Архангай гээд нэг хэлсэн дээ.Энэ Архангайн Заян гэгээн, Баянхонгорын Ламын гэгээн...

Баасанжав: Тийм, энэ гурав чинь...

Мөнхбат: Тийм тийм. Ийм домог бас сонсож байсан юм байна тийм ээ. За тэгэхээр энэ хүрээний гол шүтээн одоо анх байгуулагдсан цагаасаа одоо эдүгээ хүртэл гол шүтээн нь юу байсан юм, сахиус нь тийм ээ? Даравбандидын хүрээний?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баасанжав: Гол сахиус нь Улаан сахиус байсан юм. Тийм, Жамсран.

Мөнхбат: Энэ мандан бадарч байх үедээ одоо шашин төрийн мандан бадарч байх үедээ тэр цагийн дор энэ хүрээ маань байхдаа, одоо ид байж байх үедээ хичнээн лам хуваргатай байсан юм бол, ямар ямар сүм дуган дацантай байсан юм бол, дацангийн тоо хэд байсан юм бол, тэгээд ер нь цам майдар эргэхээс өгсүүлээд шашны төрлийн ямар ямар зан үйл явуулдаг байсан юм бол оо?

Мөнхбат: За энэ дээр бол ах нь одоо их товчлоод хэлээд байх юм бол сайн байхгүй. Энэ дээр бол арван дөрвөн дацан байсан. Хотгойд онход гэж байсан юм гэнэ лээ. Урд хэсгээр юу байсан, Шавьбандид гэж байсан болов уу гэх шүү ухааны иймэрхүү. Түлгарч байна, сайн мэдэхгүй байна. Тэгэхлээр зэрэг ийм юмнууд байсан юм гэнэ лээ. Ингээд бол харин есөн зуу гаруй ламтай байсан юм гэнэ лээ. Тэр лам нарууд бол одоо цөмөөрөө байж байгаад тэр самуунаар л алга болсон юм даа гэж ярьдаг юм билээ.

Мөнхбат: Одоо майдар эргэнэ, цам бүжиглэнэ?

Баасанжав: Майдар эргэж байсан, манай энд чинь.Цам харайж байсан энэ одоо бүх л үйлдлүүдээ бол бүрэн хийж байсан үлсүүд бий юм гэнэ лээ. Цугаараа л тэр энх тунх байж байсан үлсүүд бол хоорондоо, зарим нь бол эрт эрвээхэй ч гэх шиг, буур ч гэх шиг мэдэхгүй янз бүрийн хоч хочоороо бие биенийгээ дууддаг юм гэнэ лээ, тэрүүн дээрээ тоглож байсан юм байгаа биз дээ.Тэрийг нь сайн мэдэхгүй байна аа. Уул нь өөрсдийн л ярианы нь өнгөнөөс сонсоход тийм байна.